


Авлигын мөн чанар, шалтгаан, хор хөнөөл




Авлигатай тэмцэх газар



Танилцуулга


- Авлига нь улс орны хөгжилд саад тотгор болж, эдийн засаг, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн үр ашгийг бууруулан, ардчилал, шинэчлэлийн явцыг сааруулах хүчин зүйл болж байна.
- Сүүлийн жилүүдэд улс орнууд, олон улсын байгууллагууд авлигын эсрэг идэвхтэй тэмцэл өрнүүлэх болсон.
- Монгол Улс авлигатай тэмцэх талаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Хэл зүйн тайлбар



- ~~Авилгал~~
- ~~Авилга~~

- **Авлига**
**/ёсон бусаар
шунаж авсан
эд юм/**



CPI 2007

- 9.0 - 10.0
- 8.0 - 8.9
- 7.0 - 7.9
- 6.0 - 6.9
- 5.0 - 5.9
- 4.0 - 4.9
- 3.0 - 3.9
- 2.0 - 2.9
- 1.0 - 1.9
- no data



TRANSPARENCY INTERNATIONAL
the global coalition against corruption

Transparency International Олон улсын байгууллагаас гаргасан авлигын индекс

Он	Оноо	Байр
1999	4.3	43
2005	3.0	85
2006	2.8	99
2007	3.0	99
2008	3.0	102

Хууль эрх зүйн орчин

- 1996 он- Авлигын эсрэг хууль
- 2002 он - Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр
- 2005 он - Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийг соёрхон батлав.
- 2006 он - Авлигын эсрэг хууль
- 2007 он - ЭБШХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

Авлига гэж юу вэ?

“Авлига” гэж *Авлигын эсрэг хуулийн 4.1-д заасан этгээд*

- албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах
- бусдад давуу байдал олгох
- иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг хэлнэ.

Авлигын эсрэг хуулийн 4.1-д заасан этгээдэд:

- төрийн улс төр, захиргаа, тусгай албан тушаалд байнга, эсхүл түр хугацаагаар томилогдсон буюу сонгогдсон албан хаагч;
- төрийн болон орон нутгийн өмчит, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон захиргааны албан тушаалтан;
- олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, Ерөнхий захирал;
- төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтан;
- сонгуульд нэр дэвшигч.



Авлига хаана гарч байна?

- Хөгжлийн ямар ч түвшний улс оронд
- Төрийн эрх мэдлийг ашиглан санхүүгийн асуудлаа шийдэж болох бараг бүх газар, цаг үед гарч байна.



Субъект




● *Нэг тал*

● *Нөгөө тал*

Төрийн албан
хаагч

Иргэн,
хуулийн
ЭТГЭЭД


Авлига ямар үед үүсдэг вэ?



- **Хүсэл, сонирхол**
- **Боломж**

Авлигыг тухайн албан хаагчид санал болгож байгаа тал болон хууль бус төлбөр шаардаж буй нөгөө талын аль алианаас үүсдэг.

Авлига



- **Их ба бага хэмжээний**
- **Улс төр, захиргаа, бизнесийн**
- **Зохион байгуулалттай буюу зохион байгуулалтгүй авлига**

Авлигын хэлбэрүүд

- **Бага хэмжээний:** Дунд доод шатны ажилтнуудын бага хэмжээний хахууль буюу “цайны мөнгө”
- **Их хэмжээний:** Улсын салбар дахь бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны хүрээн дэх асар их хэмжээний мөнгө болон сангийн хөрөнгийн ашиглалт
- **Улс төрийн:** Эрх баригч намын үйл ажиллагааг санхүүжүүлэхээр улсын төсвийн мөнгийг ашиглах, сонгуулийн тойрог болон сөрөг хүчний лидерүүдэд хээл хахууль өгөх, өөрсдийн эрх ашигт нийцсэн хууль тогтоомж, бодлого гаргуулахаар нөлөөлж буй үйл ажиллагаа
- **Захиргааны:** төрийн албан хаагч нууцаар хууль бус давуу байдал олж авсныхаа хариуд бусдад давуу байдал бий болгохын тулд хууль тогтоомж, дүрэм журмыг өөр байдлаар хэрэгжүүлэх, эсхүл хэрэгжүүлэхгүй байх

Авлигын хэлбэрүүд

- Хээл хахууль авах, өгөх, зуучлах
- Албан тушаалтан албан тушаалын байдлаа урвуулах
- Албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх
- Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, иргэн, хувийн аж ахуйн нэгжид хууль бусаар олгох
- Хууль бус шан харамж, хандив, бэлэг авах
- Тал тохой татах, ах дүүсэх, найзархах
- Найз нөхөд, садан төрлийн хүмүүсээ албан тушаалд томилох, томилуулах

Ямар бэлгийг авч болох вэ?

- Хүн таны ажил үүргээ биелүүлэх байдалд нөлөөлөх зорилготой бэлэг өгвөөс авч болохгүй.

Сорил

- **Зорилго** - Энэ талархлаа илэрхийлсэн жижиг бэлэг дурсгал уу?
- **Дүрэм журам** - Үүнтэй холбогдох ямар дүрэм журам байдаг билээ? Түүнд нийцэж байна уу?
- **Нээлттэй байдал** - Бэлгийг ил тод өгч байна уу?
- **Үнэ цэнэ** - Энэ үнэтэй бэлэг үү, хямд бэлэг үү?
- **Ёс зүй** - Төрийн албаны ёс зүйд нийцэж байна уу?
- **Хэн өгснийг тодруулах** - Хэн үүнийг өгч байна?
- **Цаг хугацаа** - Та бэлэг өгөгчийн ашиг сонирхолтой холбоотой шийдвэр гаргах гэж байгаа юу?

Бэлэгний зохицуулалт

- Бэлгийг авахгүй байх нь зүйтэй хэмээн шийдвээс талархснаа илэрхийлж эелдгээр татгалзана. Бэлгийг авсан, аваагүй аль ч тохиолдолд байгууллагадаа мэдэгдэх хэрэгтэй.
- Гадаад улс орнуудад бэлэгний асуудлыг хэрхэн зохицуулдаг туршлагаас харахад байгууллагууд нь
 - авч болох бэлэгний үнэ цэнийг тогтоох (*Австрали улсад гэхэд 100 доллараас доош үнэтэй бэлгийг авч болдог*)
 - юуг өөртөө хадгалж болох болохгүй
 - томоохон бэлэг ирсэн тохиолдолд хэрхэх арга (*буцааж өгөх, байгууллагын өмч болгох, төрийн бус байгууллагуудад хандивлах зэрэг*)
 - дүрэм, журам зөрчсөн ажилтанд ямар шийтгэл хүлээлгэх зэргийг зааж өгсөн **бодлого, удирдамж** гаргадаг ажээ.

Авлигын хэлбэрүүд

- Мөнгө угаах
- Бичиг баримт хуурамчаар үйлдэх, албаны тамга, тэмдгийг ашиглах
- Мэдээллийг зүй бусаар ашиглах
- Дарамт шахалт үзүүлэх, хясан боогдуулах
- Хууль бусаар хөрөнгө эзэмших, өмч хөрөнгийг зүй бусаар зарцуулах
- Сонгуулийн авлига
- Эх орноосоо урвах, төрд тэрслэх
- Хууль бусаар баривчлах, хуурамч нотолгоо гаргах...

Авлигын шалтгаан

- төрийн байгууллагын үйл ажиллагааны хүнд суртал, ил тод, нээлттэй бус байдал
- Хууль, бодлого оновчгүй, тодорхой бус дүрэм, журам
- Хууль хэрэгждэггүй, дотоод хяналтын механизм бүрдээгүй,
- Найдвартай тогтолцоо дутагдах, авлигыг оршин тогтнох нөхцөлийг хангасан тогтолцоо
- эдийн засгийн тааламжгүй нөхцөл: төрийн албан хаагчдын цалин бага байх, амьдралын өртөг хурдацтай өсөх
- төрийн албан хаагчийн ёс зүйн доройтол
- ашиг сонирхлын зөрчилд өртөх магадлал өндөр
- Удирдлагын хэв загвар, өөрчлөлт хийх хүсэл зориг дутах
- төр засгийн шийдвэрт ил тод, хариуцлагатай байдал дутагдах: шийдвэр гаргахад албан тушаалтны хувийн үзэл бодол, сонирхол нөлөөлөх орон зай их
- Авлигыг мэдээлэхийг хүсдэггүй

Авлигын шалтгаан

- Боломж бололцоо – системтэй хяналт байхгүй байх
- Хандлага – ёс зүйн доогуур үнэлэмж
- Дарамт – цалин бага, эргэн тойрны хүмүүсийн нөлөө
- Бага эрсдэл – шийтгэгдэхээс айдаггүй

ШУНАЛ!

Авлигын хор хөнөөл

Авлигын төр засаг, нийгмийн амьдрал, хөгжил дэвшилд үзүүлэх сөрөг нөлөө асар их.

Аливаа шийдвэрийг нийгэмд үр ашигтай бус өөрт ашигтай байхаар гаргавал хир хор уршигтай байх вэ?

Авлигын хор хөнөөл

- Хүний эрх, эрх чөлөө зөрчигдөнө
 - Шударга байдал, хууль ёс алдагдана
 - Ядуурлыг бий болгоно
 - Хөрөнгө оруулалт багасна
 - Эдийн засгийг сулруулна
 - Засгийн газар хүссэн зорилгодоо хүрч чадахгүй
 - Ард түмэн төр засагтай итгэх итгэл буурна
 - Төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээ алдагдана
-

Авлигын хор хөнөөл

- Байгууллагын нэр хүнд муудах, байгууллагад олон түмний итгэх итгэл сулрах
 - Алдагдал хүлээх
 - Авлигыг илрүүлэх, шийдвэрлэх зардал
 - Сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалах, амьдралын хүрэлцээтэй түвшинд амьдрах эрхээ эдэлж чаддаггүй, тухайлбал, орон байр, цэвэр ус, шаардлагатай хоол, хүнсээр хангагдах эрх
 - Ажил хөдөлмөр эрхлэх
 - Хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлд ажиллах эрх
-

Авлигын хор хөнөөл

- Сан, хөрөнгийн хуваарилалт, үйлдвэрлэлийн бүтээмж, хэрэглээнд нөлөөлснөөс эдийн засгийн үр нөлөөгүй, үрэлгэн байдал газар авахад хүргэдэг.
 - Авлигын улмаас олсон мөнгө нь хөрөнгө оруулалт руу бараг ордоггүй, тансаг эд хөрөнгө, амьдралын хэв маягт зориулагддаг
 - Эдийн засгийн үр ашиггүй, үр нөлөөгүй, байдлыг бий болгодог.
 - Хээл хахуулийн өртөг худалдсан болон үйлдвэрлэсэн бараа, ажил, үйлчилгээнд шингэж бараа, ажил, үйлчилгээний өртөг /үнэ/-ийг хөөрөгддөг.
 - Ингэснээр эрэлт хэрэгцээ буурч, бүтээгдэхүүний өртгийн бүтэц өөрчлөгдснөөр үндэсний эдийн засаг бүхэлдээ хямралд орно.
-

Авлига нь нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сааруулдаг

- Авлига нь төрийн үйлчилгээнд зориулж хуваарилсан эх үүсвэрийг хорогдуулдаг
 - үүний улмаас баригдах ёстойгоос цөөн хэдэн сургууль, эмнэлэг баригддаг
 - Ядуу иргэд эмнэлгийн наад захын үйлчилгээ хүртэж чаддаггүй
 - Ядуу иргэд үр хүүхдээ тохирох сургуульд сургаж чаддаггүй
- Хэрэгцээ шаардлагад үндэслэж биш шийдвэр гаргагчид хир их ашигтай байхыг бодолцож шийдвэр гаргадаг

Төрийн албан хаагчийн үүрэг



Төрийн бүх шатны байгууллагын албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой асуудлыг шалгаж шийдвэрлэх нь өөрийнх нь бүрэн эрхэд хамаарахгүй байвал Авлигатай тэмцэх газарт мэдээлнэ.


Шүүгч, прокурор, цагдаа, тагнуулын байгууллагын албан тушаалтан, төрийн аудитын болон мэргэжлийн хяналтын байгууллагын, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаархи мэдээллийг нэн даруй Авлигатай тэмцэх газарт мэдэгдэх үүрэгтэй.

Авлигатай тэмцэж буй гадаад орны туршлагаас

- Улс төрийн хүсэл зоригоо илэрхийлэх
- Авлигын эсрэг ажлын төлөвлөгөөтэй болох
- Эрх чөлөөтэй, нээлттэй хэвлэл
- Иргэний нийгэм болон бусадтай түншлэх
- Төрийн үйлчилгээний хүртээмжийн талаарх судалгаа
- Авлигад өртөж болзошгүй албан тушаалд удаан ажиллуулахгүй байх
- Шударга, сайн үйлийг урамшуулах
- Ашиг сонирхлын зөрчлийн дүрэм журмыг батлан хэрэгжүүлэх
- Ёс зүйн хөтөлбөр, сургалт, маргаан...


Дүгнэлт

- Авлига нь нийгмийн сөрөг үзэгдэл бөгөөд авлига үүсэх, тархах нөхцлийг арилгаж, шударга бус, ёс зүйгүй байдлыг таслан зогсоох, төр засагт итгэх олон түмний итгэлийг бэхжүүлэхийн төлөө бүх нийтээрээ тэмцэх ёстой.
- Авлига оршин байгаа цагт нийгэм хөгжихгүй, ядуурал буурахгүй, амьдрал сайжрахгүй.
- Авлигыг та бид зогсоож чадна.



You can stop
~~CORRUPTION~~





**Анхаарал тавьсанд
баярлалаа!**